

ХСҮТ-д хэвтэн эмчлүүлэгчдийн дагаж мөрдөх журам

Та ХСҮТ-д хэвтэн эмчлүүлэх үедээ энэхүү журмыг мөрдсөнөөр өөрийн болон бусад эмчлүүлэгчийн ая тухтай байдлыг хангаж, тусламж үйлчилгээний чанарт сайнаар нөлөөлөхийн зэрэгцээ та бүхний төлөө ажиллаж буй эмч, эмнэлэгийн мэргэжилтэн, ажилчдын ажлыг хөнгөвчлөх болно.

1. Эмнэлэгт хэвтэх үед анхаарах зүйлс:

- ↓ ХСҮТ-д онош нь батлагдсан үйлчлүүлэгчийг зохих дарааллын дагуу өдрөөр болон эмчилгээний тасгуудад хэвтүүлэн эмчилнэ.
- ↓ Хэвтэхээр ирэхдээ бичиг баримтаа/Иргэний үнэмлэх,ЭМД-ын дэвтэр,хэвтэх зөвшөөрлийн бичиг,эмнэлэгийн карт/бүрдүүлэн авчирна.
- ↓ Үйлчлүүлэгч нь хувийн бэлтгэлээ сайтар хангасан байвал зохино./аяга, халбага,ариун цэврийн хэрэглэл,зөөлөн даавуун хувцас,улавч/
- ↓ Эмчилгээний тасагт хэвтэх болон гарахдаа гадуур хувцсаа тасаг,палатанд солих,хадгалахыг хориглох ба зөвхөн "Хүлээн авах"-ын хэсэгт буй"Хувцас солих өрөө"-нд сольж өмсөнө.
- ↓ Хэвтэхдээ бичиг баримт, үнэт эдлэл,хувийн эд хэрэгсэлээ ар гэртээ буцаах эсвэл "Хүлээн авах"хэсгийн "Хувцас хадгалах өрөө"-нд түр хугацаагаар хадгалуулж болно.

2. Эмчлүүлэх явцад:

- ↓ Хэвтэх хугацаанд өөрийн тасаг палатын эд хогшил,аппарат, тоног төхөөрөмжийг хайр гамтай, цэвэр үзэмжтэй эдэлж хэрэглэх ба эвдэлсэн, алдаж үрэгдүүлсэн тохиолдолд уг зүйлийг төлж байгууллагыг хохиролгүй болгоно.
- ↓ Эмчилгээ, үйлчилгээний цагаар бусад тасаг, өрөөгөөр сэлгүүцэхгүй байх, хөзөр тоглох, хөгжим, телевизорыг чанга дуугаргаж бусад эмчлүүлэгчдийн эмчилгээний дэглэм, ая тухыг алдагдуулахгүй байх
- ↓ Хэвтэн эмчлүүлэх хугацаанд эмчлэгч эмчийн зөвшөөрөлгүй тасаг, эмнэлэгийг орхин явах, гадуур хонохгүй байх.

3. Хоол хүнсний талаар баримтлах дэглэм:

- ↓ Эмчлэгч эмчийн заалтын дагуу эмчилгээний хоол хэрэглэх ба эмчийн хориглосон хоол хүнс хэрэглэхгүй байх
- ↓ Хагас боловсруулсан буюу амархан муудах бүтээгдхүүн түүхий мах авчран өрөө тасалгаанд хоол хийх, плитка, халаагуур зэрэг цахилгаан хэрэгсэл ажиллуулахгүй байх
- ↓ Өөрийн хэрэглээнээс илүүдсэн хүнсний зүйл авчрахгүй байх

4. Эмчилгээний дэглэм

- ↓ Эмчийн заалтын дагуу дэглэм баримтлана. /ердийн, хагас хэвтрийн, суугаа, хэвтрийн/
- ↓ Эмнэлэгийн дотоод дэг журмыг мөрдлөг болгон цагийн хуваарийн дагуу эмчилгээ, шинжилгээ хийлгэнэ.
- ↓ Эмчийн зөвшөөрөлгүй гаднаас эм тариа авчран хийлгэхийг хориглоно.
- ↓ Мэс засал эмчилгээ хийлгэсэн тохиолдолд боолтоо бохир гараар оролдохгүй байх, туяа эмчилгээний тэмдэглэгээг арилгахгүй байвал зохино.
- ↓ „ЭМНЭЛЭГ-ТАМХИГҮЙ ОРЧИН „ тул коридор, хонгил, бие засах газар, өрөө тасалгаандаа тамхи татаж бусад эмчлүүлэгчид болон эмнэлэгийн ажилтнуудын эрүүл мэндийг хохироохгүй байх
- ↓ Хэрвээ та тамхинаас гарахыг хүсч байвал бид танд сэтгэл зүйчийн зөвлөгөө өгч туслах болно.

5. Эргэлт авах

- ✚ Эмчлүүлэгч нь тогтоосон цагийн хуваарийн дагуу эргэлт авна. Үүнд:
Өвлийн улирал (Х/01-IV/31)-д:
Даваа – Баасан гарагт: Өглөө -Орой 07.00-20.00
Бямба –Ням гарагт: Өглөө-Орой 08.00-20.00
Зуны улирал (V/01-IX-31)-д:
Даваа – Баасан гарагт: Өглөө -Орой 07.00-21.00
Бямба –Ням гарагт: Өглөө-Орой 08.00-21.00
- ✚ Эргэлтийг зөвхөн „Хүлээн авах,-ын дэргэдэх эргэлтийн хаалгаар оруулна.

6. Эрүүл ахуйн дэглэм

- ✚ Үйлчилгээний ажилтны хөдөлмөрийг хүндэтгэн нийтийн эзэмшлийн бие засах газар, угаалтуур, шүршүүрийг зориулалтын дагуу зөв боловсон ашиглах
- ✚ Ил задгай, гадуур нь бие засахгүй байх, усаа татаж хэвших, крантны усыг хааж дадах
- ✚ Нус, цэр, тамхины иш, хог хаягдлаа ил задгай хаяхгүй байх

7. Эмчлүүлэгчийн ар гэрийнхэн анхаарах зүйлс:

- ✚ Мэс засал болон эмчилгээ оношлогооны хүндэвтэр ажилбар хийгдэж буй эмчлүүлэгчийн ар гэр,төрөл төрөгсөд 1 давхрын хүлээлгийн өрөөнд хүлээж ажилбарын дараа эмчээс мэдээлэл авах ба шаардлагатай тохиолдолд урьдчилан цаг тохиролцон уулзаж болно.
- ✚ Эмчлүүлэгчийн ар гэрийнхэн эмчилгээ үйлчилгээний цагаар тасгуудын үүдэнд олноор бөөгнөрч шуугалдан удаан хугацаанд зогсох,гар утсаар хэт чанга ярихгүй байх

8. Сахиурын баримтлах дэглэм:

- ✚ -Эмчлэгч эмчийн зөвшөөрлөөр сахиур авч болох бөгөөд сахиур нь эмнэлгийн дотоод журмыг мөрдөж эмчилгээ, сувилгааны заалтын дагуу эмч, сувиллагч, үйлчилгээний ажилтанд туслах ёстой.
- ✚ -Эмчлүүлэгчийн сахиур нь эмнэлгийн дотоод журмыг мөрдөж, зөв цэвэр хувцаслаж өрөө тасалгаагаар хэсэхгүй байх, гадагш гарч явах,байнга солигдон халдвар хамгааллын дэглэм зөрчихгүй байх

9. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчидтай харилцахдаа:

- ✚ -Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчилгээний ажилчидтай зөв боловсон харьцаж, тэдний тавьсан зүй ёсны шаардлагыг биелүүлбэл зохино.
- ✚ -Эмч эмнэлгийн ажилчидтай зүй бус харьцаж хэрүүл маргаан хийх, хэл амаар доромжлох, нэр хүндэд нь халдах
- ✚ -Архи, спиртийн ундаа ууж эмчлүүлэгчид, эмнэлгийн ажилтнуудын аюулгүй, ая тухтай байдлыг алдагдуулсан тохиолдолд эмчилгээ үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, эмнэлгээс гаргах, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх хүртэл арга хэмжээ авах болно.

10. Санал хүсэлтээ уламжлахдаа:

- ✚ -Эмчилгээ үйлчилгээ, эмч эмнэлгийн ажилтны харьцаа, ёс зүйтэй холбоотой аливаа асуудлаар өөрийн санал,хүсэлтээ тасгийн эрхлэгч болон клиникийн захирал,эмчилгээний чанарын хяналтын албанд амаар, бичгээр, утсаар хандаж шийдвэрлүүлэх эрхтэй.
- ✚ -Та санал хүсэлтээ ХСҮТ-ийн клиникийн захирлын 450712,99186186 чанарын менежер 70150437 гэсэн дугаарын утсаар өгч болно.

Батлав: Клиник эрхэлсэн дэд захирал



Г. Навчаа

Г.Навчаа

ӨВЧТӨН ЯАРАЛТАЙ ХЭВТҮҮЛЭХ ЖУРАМ

Хүлээн авах тасаг	Өвчтөний биеийн байдлын үнэлгээний шалгуур
Толгой хүзүүний мэс заслын тасаг	- Төвөнхийн өмөнгийн хожуу үед амьсгал авах, гаргахад саадтай болсон /стенот/ хавдар томорч задрах үед амьсгалын хурц дутагдалд яаралтай трахеостоми тавих, - Амны хөндий, залгиур, багалзуур, хамрын дээд эрүүний, шүлсний булчирхайнуудын өмөнгийн хожуу үед хавдар задарч том судаснаас цус алдах үед a.carotis externa-г боож цус алдалтыг зогсоох тусламж үзүүлэх. - Хамрын хөндийн болон нармайн хавдрын улмаас цус алдсан тохиолдолд хамрын өмнөд ба арын чихээс /тампон/ тавих - Толгойн хүзүүний байрлалын хавдрын улмаас хүчтэй өвдөлт өгөх үед мэдрэлийн саануудын цэгүүд дээр /блокод / хориг хийх
Ерөнхий мэс заслын ба Элэг цөс нойр булчирхайн мэс заслын тасаг	- Цус алдсан үед эрхтэн системийн хавдар мушгирсан, түгжирсэн тохиолдлууд - Хавдрын улмаас цус алдсан - Бүдүүн, нарийн гэдэсний түгжрэл - Тус төвийн мэс заслын тасагт хэвтэж мэс засал хийлгэсэн хяналтын өвчтөнүүдэд шаардлагатай тохиолдолд хүлээн авахаар яаралтай арга хэмжээ аваад үр дүн өгөхгүй бол
Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг	- Умайн дайврын үүсгэвэр мушгирч хэвлийн гялтангийн цочрол илэрсэн - Умайн цочмог цус алдалтууд - Умайн хүзүүг өөлөх эмчилгээний дараах цус алдалт - Тус төвийн эмэгтэйчүүдийн мэс заслын тасагт хэвтэж мэс засал хийлгэсэн хяналтын өвчтөнүүдэд шаардлагатай тохиолдолд хүлээн авахаар яаралтай арга хэмжээ аваад үр дүн өгөхгүй бол
Хими, Туяа эмчилгээний тасаг	- Амбулаториор хими, туяа эмчилгээ хийлгэж буй өвчтөнд эмчилгээний дараах хүндрэл гарвал - Өвчтөнөөс онош тодорхойлуулах шинжилгээ хийх үед өвчтөний биеийн байдал хүндэрсэн үед - Хавдрын онош эд, эсийн шинжилгээнүүдээр бүрэн нотлогдсон, хими, туяа эмчилгээ хийлгэхээр очерт орсон, ор хүлээгдэж байгаа өвчтөнд цус алдах, амьсгалын дутагдалд орох зэрэг үед хүлээн авахаар яаралтай арга хэмжээ аваад үр дүн өгөхгүй бол
Хөнгөвчлөх эмчилгээний тасаг	- Цус алдалтыг гэрийн нөхцөлд тогтоох боломжгүй - Задарсан хавдартай - Яаралтай мэс ажилбар шаардлагатай тохиолдолд (түгжрэл, амьсгал боогдох, шээс хаагдах, ходоод гэдэсний замын цооролт, ясны хугарал) - Хүчтэй өвдөлтийг гэрийн нөхцөлд намдаах боломжгүй - Амьсгал давчдах шинжийг гэрийн нөхцөлд намдаах боломжгүй

Жич: Яаралтай хэвтүүлэхгүй байх тохиолдол

- Хавдрын бус өвчнүүд
- Хавдар хожуу үедээ орсон, туяа, хими, мэс засал эмчилгээний эсрэг заалттай буюу яаралтай тусламжийн заалтгүй бол



БАТЛАВ: КЭДЗахирал *т.г. Д. МН*.....Г. НАВЧАА

**Хэвтэн эмчлүүлэгчдийн эргэлтийн
цагийн хуваарь**

Гаргууд	Өглөө	Орой
Даваа- Баасан	07:00 - 10:00	17:00 - 21:00
Бямба Ням	07:00 - 11:00	16:00 - 22:00

**Эргэлтийг “Хүлээн авах”-ын баруун талын
хаалгаар оруулна.**

**Жич: Өвлийн улиралд орой, 16:00—21:00 цагийн
хооронд эргэлтийг зовшоорно.**

Зөвлөх поликлиникийн үйлчилгээний стандарт

1. Үйлчлүүлэгчийг угтаж "Сайн байна уу та" гэж эелдэг мэндлэн, үзлэгээ эхлэнэ.
2. Кабинетийн нэр хаяг, байршил, ажиллах хуваарь гэх мэт мэдээллийг үйлчлүүлэгчдэд харагдахуйц газар байрлуулах.
3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг улс төрийн үзэл бодол, шашин шүтлэг, яс үндэс, хөрөнгө чинээгээр үл ялгаварлан тэгш хүртээмжтэй үзүүлнэ.
4. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг хүнлэг энэрэнгүй ёс, шинжлэх ухааны мэдлэгт тулгуурлан чанарын өндөр түвшинд гүйцэтгэнэ.
5. Хүн хүндээ нөхөр байх зарчмыг мөрдөн үйлчлүүлэгчдийн сэтгэл санааг тэтгэж ажиллана.
6. Миний үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, түүний дотны хүмүүсийн аз жаргал, сайн сайхан байдал шууд хамаарна гэдгийг ухамсарлан өөрийн эрдэм чадал, хүч авъяасаа бүрэн дайчилж ажиллана.
7. Үйлчлүүлэгчийг мэдээлэл авах, авсан мэдээлэлдээ үндэслэн сонголт хийх, цэвэр, найдвартай, аюулгүй орчинд үйлчлүүлэх, санаа бодлоо илэрхийлэх, тусламж авах, боломжоор хангаж ажиллана.
8. Өвчнийг оношлох эмчлэх, сэргийлэхтэй холбогдож хийх үйлдэл, түүний үр дагавар, эрсдэл, хүндрэлийн талаар үйлчлүүлэгч болон түүний дотны хүмүүст үнэн зөв мэдээлэл өгнө. Өвчтөний цаашдын хувь тавилан мууг мэдсээр байж хэт өөдрөг эсвэл хэт гутрангуй мэдээлэл өгч хуурахгүй байх, шаардлагагүй үйлчилгээ үзүүлэхгүй байхыг эрхэмлэн ажиллана.
9. Өвчтөний оношийн талаарх нууцыг чандлан хадгална.
10. Үйлчлүүлэгч, тухайн хүнд хийгдэж буй эмчилгээ, оношлогоо, шинжилгээг хийлгэхээс татгалзвал түүнд хүндэтгэлтэй хандан, учир байдлыг сайтар ойлгуулж, шийдвэрийг нь бичгээр гаргуулж авна.
11. Ард иргэдэд чанартай, сэтгэл ханамжтай, чирэгдэлгүй үйлчлэх үүднээс үйлчлүүлэгч бүрт товлот цагаар үйлчилнэ. Хүнд өвчтөнд дараалал харгалзахгүй үйлчилнэ.
12. Үзлэгийн дараа дахин ирэх өдөр, цагийг урьдчилан тохирч, кабинетаар үйлчлүүлсэнд нь талархал илэрхийлж үдэж гаргана.